



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Багануур дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2024/63/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Санхүү-нийцлийн аудитын
Улаанбаатар хот	Хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a>
2024 он	Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 315558 Цахим хаяг: <a href="mailto:otgonbayarda@audit.gov.mn">otgonbayarda@audit.gov.mn</a>
	Аудитор: Б.Цолмон Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:tsolmonba@audit.gov.mn">tsolmonba@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.02.23 № 235

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Багануур дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийслэлийн Багануур дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 314,434.2 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 68 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 92.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,313,684,277.00</b>	<b>1,396,809,818.00</b>
33	<b>АВЛАГА</b>	<b>1,313,684,277.00</b>	<b>1,396,809,818.00</b>
33300	Татаас, санхүүжилтийн авлага	280,066,996.00	62,935,080.00
335	<b>Бусад авлага</b>	<b>3,130,557.00</b>	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,130,557.00	-
336	<b>Зээлийн авлага</b>	<b>1,030,486,724.00</b>	<b>1,333,874,738.00</b>
3361	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	<b>1,030,486,724.00</b>	<b>1,333,874,738.00</b>
33612	Хувь хүмүүст олгосон зээл	1,030,486,724.00	1,333,874,738.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,313,684,277.00</b>	<b>1,396,809,818.00</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,313,684,277.00</b>	<b>1,396,809,818.00</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,313,684,277.00</b>	<b>1,396,809,818.00</b>
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,313,684,277.00</b>	<b>1,396,809,818.00</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	731,261,357.00	1,134,040,201.00
51220	Тайлант үеийн үр дүн	582,422,920.00	262,769,617.00
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,313,684,277.00</b>	<b>1,396,809,818.00</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>990,856,000.00</b>	<b>1,101,715,000.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>32,100,000.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	<b>32,100,000.00</b>
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	32,100,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	32,100,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>990,856,000.00</b>	<b>1,069,615,000.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	<b>1,069,615,000.00</b>
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	-	1,069,615,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>990,856,000.00</b>	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	990,856,000.00	-
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>408,433,080.00</b>	<b>838,945,383.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>408,433,080.00</b>	<b>838,945,383.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>44,945,920.00</b>
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	<b>44,945,920.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	44,945,920.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>503,856,000.00</b>	<b>793,999,463.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>408,433,080.00</b>	<b>388,421,700.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	408,433,080.00	388,421,700.00
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>95,422,920.00</b>	<b>405,577,763.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	95,422,920.00	405,577,763.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>487,000,000.00</b>	<b>262,769,617.00</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>487,000,000.00</b>	<b>262,769,617.00</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>993,825,000.00</u></b>	<b><u>1,197,137,920.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,969,000.00</b>	<b>127,522,920.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,969,000.00</b>	<b>127,522,920.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,969,000.00	127,522,920.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	32,100,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,969,000.00	95,422,920.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>990,856,000.00</b>	<b>1,069,615,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>-</b>	<b>1,069,615,000.00</b>
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	-	1,069,615,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>990,856,000.00</b>	<b>-</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	990,856,000.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,175,500,076.00</u></b>	<b><u>1,481,880,463.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,175,500,076.00</b>	<b>1,481,880,463.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>44,945,920.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>-</b>	<b>44,945,920.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	44,945,920.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,175,500,076.00</b>	<b>1,436,934,543.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>895,433,080.00</b>	<b>968,421,700.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	895,433,080.00	968,421,700.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>95,422,920.00</b>	<b>56,149,380.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	95,422,920.00	56,149,380.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>184,644,076.00</b>	<b>412,363,463.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	184,644,076.00	412,363,463.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>(181,675,076.00)</u></b>	<b><u>(284,742,543.00)</u></b>
<b>14</b>	<b>Бусад эх үүсвэр</b>	<b>181,675,076.00</b>	<b>284,742,543.00</b>
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	181,675,076.00	284,742,543.00
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>181,675,076.00</u></b>	<b><u>284,742,543.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>731,261,357.00</b>	<b>731,261,357.00</b>
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	731,261,357.00	731,261,357.00
3	Тайлант үеийн үр дүн	-	-	582,422,920.00	582,422,920.00
4	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>1,313,684,277.00</b>	<b>1,313,684,277.00</b>
5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(179,644,076.00)	(179,644,076.00)
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,134,040,201.00	1,134,040,201.00
7	Тайлант үеийн үр дүн	-	-	262,769,617.00	262,769,617.00
8	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>1,396,809,818.00</b>	<b>1,396,809,818.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,069,517,000.00</b>	<b>1,013,367,620.00</b>	<b>56,149,380.00</b>	<b>94.8</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,069,517,000.00</b>	<b>1,013,367,620.00</b>	<b>56,149,380.00</b>	<b>94.8</b>
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>45,000,000.00</b>	<b>44,945,920.00</b>	<b>54,080.00</b>	<b>99.9</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,000,000.00	44,945,920.00	54,080.00	99.9
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,024,517,000.00</b>	<b>968,421,700.00</b>	<b>56,095,300.00</b>	<b>94.5</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,024,517,000.00	968,421,700.00	56,095,300.00	94.5
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,069,517,000.00</b>	<b>1,013,367,620.00</b>	<b>56,149,380.00</b>	<b>94.8</b>
1320	<b>Улсын төсвөөс санхүүжүүлэх</b>	<b>1,069,517,000.00</b>	<b>1,013,367,620.00</b>	<b>56,149,380.00</b>	<b>94.8</b>
132001	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доот шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,069,517,000.00	1,013,367,620.00	56,149,380.00	94.8
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>		27	27	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан		1	1	<b>100.0</b>
620002	Гүйцэтгэх ажилтан		26	26	<b>100.0</b>

**Гурав. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 314,434.2 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 1,950.0 мянган төгрөгийн зөрчлийг дахин гаргахгүй байх 1 албан шаардлага, 312,484.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгсөн.

**Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтгүй гүйлгээ данс бүртгэлд тусгасан.	1	1,950.0			1	1,950.0						
Бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан.	1	4,647.6					1	4,647.6				
Төсөлд тавигдах үндсэн шаардлагыг нотлох баримтаар хангаагүй төслийг сонгон шалгаруулж /төсөл байхгүй, комиссын актын хугацаа дууссан /санхүүжилт олгосон.	1	5,000.0					1	5,000.0				
Баримтын бүрдэл дутуу төслийг сонгон шалгаруулсан нь зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэхгүй байх, найдваргүй авлага үүсэх эрсдэлийг нэмэгдүүлэх болон сонгон шалгаруулалтыг эрх тэгш үнэн зөв явагдахгүй байх нөхцөлийг үүсгэж байна.	1	120,000.0					1	120,000.0				
Тайлант онд олгосон зээлээс хугацаандаа эргэн төлөгдөөгүй буюу огт эргэн төлөлт хийгдээгүй төсөлд алданги тооцоогүй.	1	531.8					1	531.8				
Зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэл байгаа нь тусгай сангийн үйл ажиллагааг үр ашиггүй болгох нөхцөлийг үүсгэх эрсдэлтэй бөгөөд тооцооны үлдэгдлийн баталгааг төсөл хэрэгжүүлэгч нартай бүрэн гүйцэт нийлээгүй.	1	182,304.8					1	182,304.8				
<b>НИЙТ ДҮН</b>	<b>5</b>	<b>314,434.2</b>			<b>1</b>	<b>1,950.0</b>	<b>4</b>	<b>312,484.2</b>				

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		